



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/25

Өвт

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Боловсролын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн бичиг үсэггүй иргэдийг илрүүлэх судалгааг гаргах ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: Ж.Нямтогтох (1 дүгээр багийн Засаг дарга)

Д.Бямбасүрэн (2 дугаар багийн Засаг дарга)

С.Төмөр (3 дугаар багийн Засаг дарга)

Г.Пүрэвтогтох (4 дүгээр багийн Засаг дарга)

Л.Балжинням (5 дугаар багийн Засаг дарга)

Д.Дэмиддагва (6 дугаар багийн Засаг дарга)

Г.Дуламдорж (Насан туршийн боловсролын арга зүйч)

2. Судалгаанд хамрагдах хүн нэг бүрийг оношлох тестээр шалган, унших, бичих, тооцоолох чадварын түвшин тогтоох судалгааг бодитой гаргаж, 2022 оны 03 дугаар сарын 21-ны дотор нэгтгэн танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



САМГАЛАН

622101051

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/